

## Гарчиг

<b>1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b> .....	3
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл .....	3
1.2. Төслийн нэр:.....	4
1.3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр .....	4
1.4. Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:.....	4
1.5. Төслийн хүчин чадал.....	4
1.6. Түүхий эд.....	5
1.7. Туслах материал.....	5
1.8. Химийн бодисын хэрэглээ .....	5
1.9. Төслийн дэд бүтэц .....	6
1.9.1. Цахилгаан хангамж.....	6
1.9.2. Дулаан хангамж.....	6
1.9.3. Цэвэр ба бохир ус.....	6
1.10. Хог хаягдал.....	6
1.10.1. Ахуйн хатуу болон шингэн хог хаягдал .....	7
1.10.2. Технологийн хатуу болон шингэн хаягдал.....	7
1.10.3. Хийн хаягдал .....	8
1.11. Үйлдвэрийн байршил.....	8
<b>2. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ</b> .....	10
<b>3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	12
3.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт .....	15
3.2. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	16
3.3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлсэн хуваарь .....	16
<b>4. ХАВСРАЛТ</b> .....	18

## Зургын жагсаалт

Зураг 1. Архи, шар айргийн үйлдвэр.....	3
Зураг 2. Бэлэн бүтээгдэхүүн.....	5
Зураг 3. Дахин ашигладаг хог хаягдал.....	8
Зураг 4 Үйлдвэрийн байршил.....	9
Зураг 5. Техник хэрэгсэл.....	10

## Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Хог хаягдлын эх үүсвэр.....	7
Хүснэгт 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт.....	15

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

1999 онд Гадаад, дотоод худалдаа, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр байгуулагдсан. Өдгөө улаан буудайн онцгой болон тансаг спирт, архи, шар айраг, цэвэр усны үйлдвэрлэл худалдаагаар үндсэн үйл ажиллагаа явуулж байна. 2003 онд ОХУ-н Тамбов хотын Комсомолец нийгэмлэгийн төслөөр архины Тэргүүн үйлдвэрийг барьж ашиглалтан оруулсан. Тус үйлдвэр нь уламжлалт технологиор жилдээ 700 000 dal хүртэлх цагаан болон өвөрмөц архиудыг үйлдвэрлэх хүчин чадалтай. Тэргүүн үйлдвэр нь өөрийн нэрийн Chinggis Gold, Алтанбуудай, Тэргүүн мөн Орон нутгийн цуврал брэндүүдийг өөрийн гэсэн онцлог жор технологи, өвөрмөц сав баглаа боодлын шийдэл бүхий сархдуудыг хэрэглэгчдэд хүргэж байна.

2006 онд ХБНГУ-н LEMKE BREW Systems компаний ЖЕМ ДРАФТ амьд шар айрагны үйлдвэрийг байгуулсан. Төслийн онцлог нь амьд шар айрагийг хэрэглэгчдэд орчин үеийн түгээлтийн технологи болох ХХТ (Хөдөлгөөнт Хөргөлттэй Танк)-аар түгээдэг нь бусад шар айрагнаас онцлогтой юм. Ингэснээр хэрэглэгч зөвхөн pub, bar, ресторанаас амьд шар айргийг уух биш супермаркет бусад дэлгүүрүүдээс худалдаж авах боломжтой болж байгаа юм. 2009 онд Өвөрхангай аймгийн Хужирт байгалийн цогцолбор газарт Хужирт байгалийн эрдэст усны үйлдвэрийг ашиглалтанд оруулсан нь Улаанбаатар хотын агаарын болон орчны бохирдлоос 400 км-ийн зайнаас тээвэрлэн авчирч, хүний өдөр тутмын эрдэсийн хэрэгцээг хамгийн зохимжтой түвшинд хангах боломжийг олгож байгаагаараа Хужирт байгалийн эрдэст ус нь бусад цэвэр уснаас ялгагдах гол давуу тал юм.

Компаний засаглал, менежментийг улам сайжруулан Олон Улсын жишигт нийцүүлэн "Чанарын Удирдлагын тогтолцоо ISO 9001:2008", Кайзен, Борлуулалтын "Preselling" системүүдийг амжилттай нэвтрүүлэн ажиллаж байна.



Зураг 1. Архи, шар айргийн үйлдвэр

**1.2. Төслийн нэр:** “Архи, шар айргийн үйлдвэр”

**1.3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:** “Жем Интернэшнл” ХХК

Улсын бургтэлийн дугаар: 9011145111, Регистрийн дугаар: 2612046

**1.4. Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:**

Монгол улс, 17061 Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг, 3 -р хороо, Чингисийн өргөн чөлөө 200/19 Жем Интернэшнл ХХК -ийн байр, утас: 77997799, Мэйл: info@gem.mn

## 1.5. Төслийн хүчин чадал

“Жем интернэшнл” ХХК-ийн “Жем Драфт шар айргийн үйлдвэр” нь 2007 онд анх хагас автомат технологитой байгуулагдан ажиллаж эхэлсэн байна. Тус үйлдвэр өнөөгийн байдлаар 12 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна. Хамгийн сүүлийн үеийн хагас автомат технологи бүхий дараах тоног төхөөрөмжөөр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

1. Чаналгын тогоо;
2. Исгэлт, барилтын танк (Lefler фермийн) нь ХБНГУ болон Голланд улсад үйлдвэрлэгдсэн;
3. Хөргөлтийн машин (Hafler muschler) зэрэг зэвэрдэггүй гангаар хийгдсэн төхөөрөмжүүд;
4. Түүхий эд хадгалах 165.8 м<sup>2</sup> агуулах
5. Исгэлтийн 5000 литрийн багтаамжтай танк, барилтын 24 ширхэг танк;
6. Үйлдвэрийн хими, микробиологийн лаборатори.

“Жем Драфт шар айргийн үйлдвэр” нь хоногт 5-6 мян.л шар айраг үйлдвэрлэх хүчин чадалтай. Тус үйлдвэр нь дараах төрлийн шар айраг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлдэг байна. Үүнд:

1. Жем драфт хар: Хорекад-20 л, 30 л, 50 л /торхонд/ 2007 оноос хойш;
2. Жем драфт шар: Хорекад-20 л, 30 л, 50 л /торхонд/ 2007 оноос хойш,
3. Жем крафт төрөл: Бүх салбаруудад-0.5 л /лонхонд/ 2017.07 сараас хойш.



## Зураг 2. Бэлэн бүтээгдэхүүн

“Жем интернэшнл” ХХК-ийн архины үйлдвэр нь 2003 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна. Энэхүү үйлдвэр нь АНУ, Итали, Болгар, ОХУ-ын хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт техник-технологи, тоног төхөөрөмж ашиглан, үйлдвэрлэлээ явуулдаг бөгөөд нийт 60 гаруй ажилтантай юм. Уламжлалт технологиор жилдээ 700000 дека литр (дал) архи үйлдвэрлэх хүчин чадалтай орчин үеийн үйлдвэр байна.

Тус үйлдвэр нь өөрийн спиртийн үйлдвэрийн дээд зэрэглэлийн альфа спирт, газрын гүний цэнгэг ус зэрэг түүхий эдүүдийг ашиглан мембран шүүлтүүр, мөнгөжүүлсэн 4 шүүлтүүр, тунгалагжуулах шүүлтүүрээр шүүж, стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.

“Жем интернэшнл” ХХК-ийн архины үйлдвэр нь найман нэр төрлийн цагаан архи үйлдвэрлэхээс гадна, өвөрмоц амт, загвар бүхий пиво үйлдвэрлэн гаргаж байна. Архины үйлдвэрлэл нь үйлдвэрлэгчийн баталсан технологийн заавар, горимын дагуу шүүн савладаг.

### 1.6. Түүхий эд

Жем Драфт шар айргийн үйлдвэр нь технологийн үндсэн түүхий эдэд дараах материалуудыг ашигладаг. Үүнд:

- Ус
- Арвайн соёолж /Герман улсаас импортлон оруулж ирдэг/
- Зөрөг цэцэг /Герман улсаас импортлон оруулж ирдэг/
- Хөрөнгө

Архины үйлдвэрийн түүхий эдэд дараах материалуудыг ашигладаг. Үүнд:

- УСУГ-ын гүний худгийн ус
- “Жем Интернэшнл” ХХК-ний спиртний үйлдвэрийн спирт

### 1.7. Туслах материал

“Жем интернэшнл” ХХК-ийн үйлдвэрүүд нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, цех дамжлагуудад дараах туслах материалуудыг дотоод болон гадаадын зах зээлээс худалдан авч ашигладаг байна. Үүнд:

- Шилэн лонх;
- Хуванцар лонхны бэлдэц;
- Төмөр торх;
- Бүх төрлийн бөглөө;
- Рулон;
- Савны хуванцар барнул;
- Цаасан хайрцаг;
- Полиэтилен хальс
- Шошго г.м.

### 1.8. Химийн бодисын хэрэглээ

“Жем интернэшнл” ХХК-ийн архи, шар айргийн үйлдвэрүүд нь ХБНГУ-ын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон микробиологи, химийн шинжилгээний лабораториудыг

ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх бүхий л үе шатанд чанар, аюулгүй байдлын хяналтыг тогтмол хийдэг байна. Тус лабораториуд нь “Стандартчлал, хэмжилзүйн газар”-аас итгэмжлэл авсан. Мөн тус үйлдвэрүүд нь үйлдвэрийн шугамын ариутгал цэвэрлэгээнд химийн бодисууд хэрэглэдэг байна. Эдгээр бодисуудаас онц аюултай - 5, их аюултай - 42, дунд аюултай - 28, бага аюултай - 91 төрлийн бодис тус тус байх бөгөөд нийт бодисуудын 55% нь багатай аюултай, 25% нь их аюултай, 17% нь бага аюултай, 3% нь онц аюултай бодисууд байна. БОННУ ний тайлангийн химийн бодисны эрсдэлийн үнэлгээний хэсэгт заагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

## **1.9. Төслийн дэд бүтэц**

### **1.9.1. Цахилгаан хангамж**

Тус байгууллага нь цахилгаан хангамжаа “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-тай байгуулсан гэрээний үндсэн дээр хотын цахилгаан түгээх сүлжээний нэгдсэн системээс хангадаг.

### **1.9.2. Дулаан хангамж**

Тус байгууллага нь дулаан хангамжаа “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-тай байгуулсан гэрээний үндсэн дээр хотын төвлөрсөн дулааны шугам сүлжээнээс хангадаг. Тус цех нь технологийн уурыг ДЦС-IV ТӨХК-иас гэрээний үндсэн дээр авч хэрэглэдэг байна.

### **1.9.3. Цэвэр ба бохир ус**

Тус байгууллага нь цэвэр ба бохир усыг Ус Сувгийн Удирдах газартай байгуулсан гэрээний дагуу авч ашигладаг байна. “Жем интернэшнл” ХХК-ийн нь шар айргийн үйлдвэрлэлдээ ашиглах цэвэр усыг хотын төвлөрсөн ус хангамжийн шугам шүлжээнээс Ус сувгийн удирдах газартай байгуулсан гэрээний үндсэн дээр татан авч хэрэглэдэг. Гэрээний дагуу тоолуурын заалтаар ус ашигласны төлбөрөө төлдөг байна. Архины үйлдвэрлэлдээ Ус сувгийн удирдах газрын дугаар бүхий гүний худгаас ус зөөвөрлөн авч ашигладаг байна. “Жем интернэшнл” ХХК-ийн “Архи, шар айргийн үйлдвэр төсөл” нь өдөрт нийтдээ 94.6 м<sup>3</sup> ус хэрэглэдэг байна. Мөн дундажаар сард 2838 м<sup>3</sup>, жилд 34056 м<sup>3</sup> ашигладаг.

## **1.10. Хог хаягдал**

“Жем Интернэшнл” ХХК-ний спиртний үйлдвэрийн үйл ажиллагаанаас ахуйн гаралтай хатуу шингэн, технологийн гаралтай хатуу, шингэн хог хаягдлууд үүсэж бий болно.

Хог хаягдлын эх үүсвэрүүд:

1. Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад ажилчдын ажиллах болон амрах байр зэргээс ахуйн хатуу, шингэн хог хаягдал;
2. Үйлдвэрлэлийн технологийн систем угаалтаас хаягдал ус, савлах, баглах үйл ажиллагаанаас сав баглаа боодлын хаягдал;
3. Тээвэрлэлт, түгээлтний автомашины эвдрэл, засвар үйлчилгээтэй холбоотойгоор эвдэрсэн эд анги, дугуй, ашигласан тос, тослогооны материалын сав зэрэг хаягдал.

4. Үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдийн эвдрэл, гэмтэл засвар үйлчилгээтэй холбоотойгоор эвдэрсэн эд ангийн хаягдлууд хамаарна.

Тус компанийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас аюултай болон аюулгүй хог хаягдлууд бий болно. Үүсэх хог хаягдлын ангилал, анхдагч эх үүсвэр болон төрлийг доорх хүснэгтээр үзүүлэв.

*Хүснэгт 1. Хог хаягдлын эх үүсвэр*

№	Хог хаягдлын ангилал	Үүсэх хог хаягдлын төрөл	Үүсэх хэмжээ	Үүсэх эх үүсвэр
1	Ахуйн гаралтай хог хаягдал	Цаас, баглаа боодол, хоолны үлдэгдэл, шил, хуванцар сав, лааз зэрэг ахуйн хог хаягдал	Ойролцоогоор жилд 2.7 тн	Ажилчдын ахуйн хэрэглээнээс
2	Аюултай хог хаягдал	Принтерийн ашигласан картеж, өдрний гэрэл, ашигласан зай хураагуур г.м	Урьдчилан гоггоох боломжгүй.	Оффис

### 1.10.1. Ахуйн хатуу болон шингэн хог хаягдал

Тус үйлдвэр болон ажилчдын ахуйн хэрэглээнээс цаас, цаасан хайрцаг, хоолны үлдэгдэл, ундааны сав зэрэг ахуйн хатуу хог хаягдал гарна. Тус байгууллагад нийт 50 хүн ажилладаг бөгөөд нэг хүн өдөрт 0.5 кг хатуу хог хаягдал гаргана гэж үзвэл, тооцоогоор үйлдвэрийн нийт ажилчдаас өдөрт 25 кг, сард ойролцоогоор 750 кг хатуу хог хаягдал гарахаар байна. Ахуйн хэрэглээнээс гарсан хатуу хог хаягдлыг хашааны зүүн урд хэсэгт байрлах хатуу хучилт хийсэн хогийн цэгт төмөр хогийн саванд түр хадгалан Хан-Уул дүүргийн ТҮК-тэй байгуулсан гэрээннй дагуу сард дунджаар 1 удаа тээвэрлэн хотын нэгдсэн цэгг хаядаг. Ахуйн хэрэгцээнээс гарсан бохир усыг төв цэвэрлэх байгууламжийн шугам хоолойд нийлүүлнэ. Тус компани нь УСУГ-тай цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах гэрээг жил бүр хийдэг байна.

### 1.10.2. Технологийн хатуу болон шингэн хаягдал

Үйлдвэрлэлээс гарч буй хаягдал усыг төв цэвэрлэх байгууламжийн шугам хоолойд нийлүүлнэ. Төлбөрийг “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах гэрээ”-нд заасны дагуу УСУГ-т төлнө. УСУГ нь тус үйлдвэрийн технологийн үйл ажиллагаанаас гарч буй дээрх хаягдал уснаас дээж авч шинжилгээнд хамруулдаг байна. Технологийн үйл ажиллагаанаас гарсан хаягдал цаас, хайрцаг савыг дахин ашигладаг.




*Зураг 3. Дахин ашигладаг хог хаягдал*

### 1.10.3. Хийн хаягдал

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн төв нь үйлдвэрийн гадаад орчны агаарын чанарын хэмжилтийг хими, микробиологийн лабораторийн агааржуулалтын хоолойн гадна хэсгээс авсан ба үр дүнг “Агаарын чанарын стандарт - MN34585:2016”-гай харьцуулахад бохирдуулагч бодис  $\text{NO}_2$ ,  $\text{SO}_2$  хийн агууламж ЗДХ-ний хязгаарт, нийт тоосны агууламж ЗДХ-ээс хэтрээгүй үзүүлэлтэй гарсан. Мөн үйлдвэрийн байрны дотоод орчны агаарын чанарын хэмжилтээр  $\text{NO}_2$ ,  $\text{SO}_2$  хий, нийт тоосны агууламж ЗДХ-ний хязгаарт буюу МУ-ын стандарт “ХААЭА, Ажлын байрны орчин MN54990:2015” шаардлагыг хангаж байна.

### 1.10.4. Үйлдвэрийн байршил

Тус үйлдвэр нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт Эрэл ХХК-н үйлдвэрийн дэргэд (4-р зураг)  $10430 \text{ м}^2$  талбай бүхий газарт байрлана. Төсөл хэрэгжих талбай нь төв замаас 310 м зайд, хатуу хучилттай замаар холбогдсон.



*Зураг 4 Үйлдвэрийн байршил*

## 2. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрээр авч үзвэл жишээ нь агаарын чанарт үзүүлэх гол сөрөг нөлөөллийн эх үүсвэрт түгээлтийн дизель 10 ачааны машин орно.



Зураг 5. Техник хэрэгсэл

Үйлдвэр нь Сэлбэ голоос урагш 1 км, Туул голын хойд эрэгт 800 м зайд байрлаж байгаа тул гадаргын усан санд шууд үзүүлэх сөрөг нөлөөлөл байхгүй.

Гүний усыг технологийн хэрэгцээнд ашигладаг тул усны нөөцөд шууд сөрөг нөлөө үзүүлэхээр байна. өдөрт ойролцоогоор  $61 \text{ м}^3$ , сард  $1830 \text{ м}^3$  ус ашигладаг.

Үйлдвэрийн талбай нь бүрэн хатуу хучилттай болсон тул хөрсөн бүрхэвч эвдрэх, бохирдох сөрөг нөлөөлөл байхгүй болсон.

*Шууд нөлөөлөлд:* Бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон түгээлтийн үйл ажиллагаанаас үүдэн агаарын бохирдол, дуу чимээ, ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх байдал, хог хаягдлын цэгийн ариутгал зайлуулалт муугаас орчин бохирдож эвгүй үнэр тархах, элдэв шавьж үржих нөхцөл бүрдэх, санамсар болгоомжгүй болон бусад тохиолдлоос үүдэн гал түймэр гарах, химийн бодис алдагдах зэрэг шууд сөрөг нөлөөллүүд байна. Харин нийгэм эдийн засагт эерэг хувь нэмэр оруулах, хүн амын эрүүл мэнд хүнсний хангамжинд нөлөөлөх, татварын орлого улсын төсвийг нэмэгдүүлж, ажлын байр топмол нэмэгдэх зэрэг эерэг нөлөө үзүүлнэ.

*Шууд БУС нөлөөлөлд:* Уур амьсгалын бичил өөрчлөлтөд нөлөөлөх, байгалийн гамшигт үзэгдэл явагдах нөлөөллүүд багтаж байна.

*Богино хугацааны нөлөөлөлд:* Тус үйлдвэрийн үйл ажиллагааны үед санамсаргүй болон ямар нэгэн техникийн ослын улмаас химийн бодис алдагдсан тохиолдолд богино хугацаанд орчныг бохирдуулах, ахуйн хатуу хог хаягдлыг графикт хугацаанд нь ачуулаагүй болон

ариутгал хийлгүй удсанаас дулааны улиралд эвгүй үнэр гарч хортон шавьж, ялаа хорхой үржих нөхцөлийг бүрдүүлэх, гал түймэр гарах, газар хөдлөл явагдах зэрэг сөрөг нөлөөллүүд богино хугацааны нөлөөлөлд хамаарахаар байна.

*Дунд хугацааны нөлөөлөлд:* Үйлдвэрийн түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэлтийн үйл ажиллагааны үед авто машинаас гарах дуу чимээ, утаа нь агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл болно. Хүн амын орлого, орон нутгийн орлого, татварын орлого нэмэгдэх, ажлын байр нэмэгдэх, ядуурлыг бууруулахад дэмжлэг болох зэрэг нь эерэг нөлөөлөл болно.

*Урт хугацааны нөлөөлөлд:* Ус хэрэглэдэг учир гүний усны ашиглалт, түүнээс улбаалан гүний усны нөөцөд нөлөөлөх, эрчим хүчний хэрэглээ, түгээлтийн үйл ажиллагааны үед Улаанбаатар хотын хөрсний элэгдэл, бохирдолд үзүүлэх сөрөг нөлөөлөл хамрагдана.

*Буцах нөлөөлөл.* Үйлдвэрийн процессийн үйл явцад гарах дуу чимээ нь ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх, ахуйн хог хаягдлын ариутгал, зайлуулалт муугаас орчин бохирдож элдэв шавьж үүсэх нөхцөл бүрдэх нь буцах чиглэлийн нөлөө үзүүлнэ.

*Буцалтгүй нөлөөлөл:* Үүнд агаарын чанарын өөрчлөлт, уур амьсгалын бичил өөрчлөлт, ус ашиглалт, гал түймэр, газар хөдлөл, химийн бодис алдагдах зэрэг нөлөөллүүд багтана.

### 3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээн ий цар, хэмжээ	Хэмжих нэгж, мян.төг	Биелэлтийн шалгуур	Биелэлт
Хөрсөн бүрхэвч				
Үйлдвэрийн орчны зам талбайг хатуу хучилттай болгох (хөрсийг хуулан 3-5 см зузаан шавар үеийг нягтаршуулан болзошгүй тохиолдлоор бензин, тос гоожих, асгарах нөхцөлд доош хөрсөнд нэвчихээс хамгаалсан хаалт (екран) хийн дээрээс нь цардсан (цементэн) хучлага хийж өгөх)	Үйлдвэр ийн хашаанд	3,750,0	Ажлын явцийг зургаар баталгаажуулах	Үйлдвэрийн талбай бүрэн хатуу хучилттай болсон ба 2020 онд 25 мкв талбайд гоёлын чулуун зам суулгасан.
Хог хаягдлыг тусгайлан бэлтгэсэн зориулалтын талбайд хаяагүйгээс хөрсөн бүрхэвч бохирдох, хог хаягдал дээр хорхой шавьж, шувуу цугласнаар элдэв өвчин тархах учир урьдчилан сэргийлж зориулалтын саванд түр хадгалж, тогтмол зайлуулж байх	Үйлдвэр ийн хашаанд	-	Ажлын явцийг зургаар баталгаажуулах	Ус, ундааны хаягдал цуглуулах сав 3ш компаны хашаанд байрлах тусгай цэгүүдэд байрлуулав. Хогны савыг хавсралтын 1-р зурагнаас харна уу.
Дахивар ангилан ялгах цэгийг засварлаж, шинэчлэлт хийх	Үйлдвэр ийн хашаанд	-	Ажлын явцийг зургаар баталгаажуулах	Тасалгаат хогны савыг хавсралтын 2-р зурагнаас харна уу.
Агаарын чанарт нөлөөлөх				
Тээврийн хэрэгслийн үйлчилгээ оношлогоог тогтмол хийх, агаар бохирдуулсаны төлбөр төлөх	Бүх тээврийн хэрэгсэл	200.0	10 тээврийн хэрэгсэл	Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогоод орсон, өөрийн засварын төвд үйлчилгээг тогтмол хийдэг.
Үйлдвэрийн хашаанд тоосжилт үүсэх	Үйлдвэр ийн хашаа	100.0	Үйлдвэрийн нийт талбай	Үйлдвэрийн нийт талбай хатуу хучилттай, гадаах талбайн цэвэрлэгээг тогтмол хийдэг.

Ногоон байгууламж байгуулах ажлын хүрээнд эко орчин төсөл хэрэгжүүлж байна.	Үйлдвэр ийн хашаа	6,853,5	Тогтмол арчлах	360 мкв талбайд ногоон зүлэг, 13 гацуур модыг шилжүүлэн суулгасан байна.
Ажилтнуудын эрүүл мэнд				
Эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэх	Нийт ажилчид ад	-	Тогтмол	Халдварт өвчний тархалтаас сэргийлэх зорилгоор ажилчдад гар ариутгалын спиртэн уусмалыг нийт 80 ажилтанд давтамжтай 150 литер гар ариутгагч спирт тараасан, мөн Ажлын байранд 70% спиртийн агууламж бүхий гар халдваргүйжүүлэх бодис байршуулсан
Тоног төхөөрөмжтэй ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгөх	Бүх ажилчид	Нийт 40 ажилтан	Жил бүр	Зааварчилгаа өгөх, тогтмол хяналт тавих ажлын байранд хүн томилон ажиллуулдаг. ХАБ-н мэдээллийн самбарт мэдээллийг байршуулж, хамгаалах хувцас хэрэгсэлийг олгосон. ХАБ-н мэдээллийн самбарыг 3-р зурагнаас харна уу.
Үйлдвэрийн бүх ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдлийг бууруулах ажлууд хийгдсэн	Бүх ажилчид	Нийт 40 ажилтан	Тогтмол	Эрсдлийн үнэлгээний хүснэгтийг 4-р зурагнаас харна уу.
Гал түймрээс сэргийлэх, гал унтраах багаж хэрэгслийг байнгын бэлэн байдалд байлгах, ажиллагсад сургалт явуулах, бусад мэдээ мэдээлэл анхааруулгыг байршуулах, галын дүгнэлт гаргуулах	Үйлдвэр ийн хашаа	Суурьлу улах, бэлэн байдлыг шалгах	Жил бүр	Байршуулсан, ХУД-н онцгой байдлын хэлтэсийн дүгнэлт гаргуулсан. Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийг 5-р зурагнаас харна уу.
Ажилчдыг эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт оруулах, Үзлэгийг ЭМН-ийн Сайдын 1999 оны А/243 тушаалын дагуу явуулах	Нийт ажилтан	100.0	Жил бүр	Шинжилгээнд хамруулсан үзлэгийн хуудас, ХУД-н эрүүл мэндийн төвтэй хамтран ажилласан. Шинжилгээнд хамрагдсан ажилчдын бүртгэлийг 6-р зурагнаас харна уу.

Ажилчдын ажиллах аюулгүй, ая тухтай нөхцөлийг бүрдүүлэх	Үйлдвэрийн орчинд	-	Тогтмол засаж сэлбэх	MNS 6458:2014 стандартын шаардлагын дагуу агуулахыг тохижуулсан. ХАБЭА тухай хуулийн хүрээнд ажилчдын амрах, хувцас солих өрөө, хоолны газрыг тохижуулсан.
Бусад ажил				
Хүнсний аюулгүй байдлыг хангах, халдварт өвчнийг дамжуулах элдэв шавьж, мэрэгчийг устгах ажлыг тогтмол гэрээний дагуу мэргэжлийн байгууллагаар хийлгэж байна.	Байгууллагын удирдлага	150.0	Улирал тутам	Ахуйн шавьж, мэрэгч устгал халдваргүйлэлтийн ажлын гэрээг 7-р зурагнаас харна уу.
АҮ, ПҮ-д Ус сувгаас хийлгэсэн бохирын шинжилгээний үр дүнд монгол улсын стандартын шаардлага хангасан	Үйлдвэрийн орчинд	-	-	Усны сорилын дүгнэлтийг 8-р зурагнаас харна уу.
250 сая төгрөгний үнэ бүхий архины шилийг худалдан авч дахин ашигласан	Үйлдвэрийн орчинд	250.000	-	Эргэлтийн шилний тоо ширхэгийн мэдээллийг 9-р зурагнаас харна уу.
Хаягдал шилийг угаан дахин хэрэглэх замаар хөрсний бохирдлийг багасгах үүднээс эргэлтийн шил худалдан авах 4 цэгийг бий болгов.	4 цэгтэй	-	2024 он болон 2025 онуудад үйлдвэрлэгдсэн шилнүүдийн тоо хэмжээг харгалзан үзэж тухайн онуудад эргэлтэд оруулсан шилний тоотой харьцуулах	Шил угаах цех, шил авах гэрээт цэгүүд, хаягдал шил авах гэрээг 10,12,13,14-р зурагнаас харна уу.

### 3.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарч ажиллахаас гадна олон нийтэд чиглэсэн ажлыг хийж гүйцэтгэнэ.

*Хүснэгт 1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт*

№	Хийгдэх ажил	Холбогдох хууль, дүрэм, журам, стандарт	Биелэлт
1	Химийн цэвэрлэгээний бодисын зарцуулалтын бүртгэлтэй болох, мэргэжлийн байгууллагаар устгуулах ажлын хүрээнд Элемент ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна	Химийн бодисын ашиглалт, зарцуулалтын бүртгэл хөтлөх аргачилсан заавар /Байгаль орчны сайдын 2000 оны 45 тоот тушаал/	Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, устгах, халдваргүйжүүлэх гэрээг 11-р зурагнаас харна уу.
2	Байгаль орчны аудит 2 жил тутамд хийлгэх	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	Байгаль орчны аудит хийлгэсэн.
3	Нийгмийн хариуцлагын хүрээнд гүйцэтгэх ажил		Нийгмийн хариуцлагын хүрээнд сугалаат аян явуулж Замын цагдаа, Онцгой байдлын ерөнхий газар, Улаанбаатар хот дах гал унтраах бүх ангиуд, Дүүргийн тохижилт үйлчилгээний компаниуд, Автобус компаниуд, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэгүүдэд “Red Bull” үнэгүй тараав. Хавсралтыг 15-р зурагнаас харна уу.

### 3.2. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг	Гүйцэтгэл
Агаарын бохирдлын цэгэн эх үүсвэр болох агаарын чанарын бүх үзүүлэлтээр хянах /жишээ нь TSP, SO <sub>x</sub> , NO <sub>x</sub> , CO <sub>x</sub> г.м/	Мг/м <sup>3</sup>	Цехийн орчинд	2024 он	Агаарын бохирдлын цэгэн эх үүсвэрийг хяналтын хэмжих горимоор хийх	-	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвөөр гүйцэтгүүлсэн.
Ажлын байрны агаарын найрлага, тоосжилт чийгшил хэмжих арга хэмжээ авах	Мг/м <sup>3</sup>	Ажлын байранд	2024 он	Ажлын байранд эрүүл ахуйн хэмжилт шинжилгээ хийх	-	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвөөр гүйцэтгүүлсэн..
Хөрсний бохирдол, ялзмагийн агууламж, рН, давсжилт, чийгшил, NO <sub>3</sub> -N, P <sub>2</sub> O <sub>5</sub> , K <sub>2</sub> O, рН, нийт азот, нийт фосфор	%, dS/m, мг/100г, см,	Цехийн орчинд	2024 он	Хөрсний хяналт шинжилгээг хөрсний дээж авах стандартыг баримтлан авах	-	Үйлдвэрийн хашаа дотор болон хог хаягдлын цэг бүрэн хатуу хучилттай болсон.
Бохир усны хаягдалд хэмжилт хийлгэх	м <sup>3</sup>	Цехийн хаягдал ус	2025 он	Жилд 2 удаа	<b>150.0</b>	УСУГ гэрээ байгуулан бохир усыг нийлүүлдэг ба энэ үе шатанд тогтмол бохир усанд хэмжилт хийдэг.

### 3.3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлсэн хуваарь

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлнэ. Хариуцсан ажилтан томилоогүй, мөн цар тахалтай холбоотой Нийслэлийн Байгаль Орчны Газар хэрэгжилтийн тайланг үнэлүүлж, БОНХЯ аар тухайн жилийн төлөвлөгөөг батлуулаагүй.

БОМТ хэрэгжилтийг тайлагнах,	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
------------------------------	--------------------------	--------------------	---------------	---------------------------------	------------------------

хэлэлцүүлэх байгууллагууд					
Бүх шатны Засаг дарга, Байгаль орчны улсын байцаагч, орон нутгийн байцаагч	Биелэлтийн тайлангийн үр дүнг хэлэлцүүлсэн	БОМТ-ний хэрэгжилтийн тайлан	Жил бүрийн 4, 10-р сарын 15 –нд 2 удаа	Ажлаа танилцуулж биелэлтийг шалгуулах	БО-ны улсын байцаагч, орон нутгийн байцаагч
Төрийн бус байгууллага, олон нийт	Олон нийтийн хурал зохион байгуулсан-1 удаа	БОМТ-ний хэрэгжилтийн тайлан	Жил бүрийн 5-р сард нэг удаа	Хурал, хэлэлцүүлэг, өдөрлөг зохион байгуулах	ХУД 3-р хороо

#### 4. ХАВСРАЛТ



*Зураг 1. Зориулалтын хогны сав*



*Зураг 2. Зориулалтын хогны сав*



Зураг 3. ХАБ-н мэдээллийн самбар

НЭХ АГУУДАЛ ХИЙСЭН ЭРСДЛИЙН ҮНЭЛЭЭЖ ЗӨР ИЛЭРСЭН ХАБЭА-Н ЗӨРЧЛИЙН АРИШАХ ШААРДЛАГА										
1	Шалгалтаг хүргэсэн			ХАБЭА				ШААРДЛАГЫН ДАГУУ ХИЙСЭН АЖЛЛ		
2	Шалгалтаг хүлээн авсан албаны нэр			ДОМЖИТВИЙН ГАЗАР						
4	№	Зөрчил илэрсэн огноо	Зөрчлийн талаар	Учраг эрсдэл	Зөрчлийн арг	Авал арга хэвцэл	Зөрчлийн зураг	Зөрчлийг аришгах хугацаа	Ажилын байдал	Ажилын зураг
13	9	2021.07	бэлэн бүтээгдэхүүнээс бусад хөнгөрсөнгүй зүйл тавигсан	Гэмтэл бэрхэл гарах	Агуулах	бүтээгдэхүүнээс бусад хөнгөрсөнгүй зүйл тавигсгүй байх		Даруй		
14	10	2021.07	Агуулахад бэлэн бүтээгдэхүүнээс бусад хөнгөрсөнгүй зүйл тавигсан	Дотоод хана дагуух 50 см өргөнтэй хэсэгт эд зүйл байх хортой	Агуулах	Агуулахад бэлэн бүтээгдэхүүнээс бусад хөнгөрсөнгүй зүйл тавигсгүй байх		Даруй		

Зураг 4. Эрсдлийн үнэлгээний хүснэгт



**Шалгалт хийсэв тухай тэмдэглэл**

№	ШАЛГАХ ТӨГӨӨГ	ХАМРАХ АХУЙ	ШАЛГАЛТЫН ХАМРАГТУУХАН	СТАНДАРТ ДҮГНЭЭНИЙН ХАМРАГТУУХАН	ШАЛГАЛТЫН ХАМРАГТУУХАН
1	Боловсрол, хамгаалалт, байдал, аюулгүй байдал, ажил үйлчилгээний байдал, ажил үйлчилгээний байдал, ажил үйлчилгээний байдал	Т.Х. УРТИГОВ	+	+	+
2	Төрийн байгуулалтын байдал, ажил үйлчилгээний байдал, ажил үйлчилгээний байдал	Д. УРТИГОВ	-	+	+
3	Төрийн байгуулалтын байдал, ажил үйлчилгээний байдал, ажил үйлчилгээний байдал	Д. УРТИГОВ	-	+	+
4	Бүтэц				

Зураг 5. Дүгнэлт

Хамрагтнууд: *Хүн, Ногооног, МЭ, -LV, ХНД*  
 ХНД, өм. Д. Уртигов

№	Огноо	Ивч	Хамрагтнууд	Утас	Шинжилгээ
1	11.05.2013	Б.Ур	11.05.2013	11.05.2013	11.05.2013
2	12.05.2013	Б.Ур	12.05.2013	12.05.2013	12.05.2013
3	13.05.2013	Б.Ур	13.05.2013	13.05.2013	13.05.2013
4	14.05.2013	Б.Ур	14.05.2013	14.05.2013	14.05.2013
5	15.05.2013	Б.Ур	15.05.2013	15.05.2013	15.05.2013
6	16.05.2013	Б.Ур	16.05.2013	16.05.2013	16.05.2013
7	17.05.2013	Б.Ур	17.05.2013	17.05.2013	17.05.2013
8	18.05.2013	Б.Ур	18.05.2013	18.05.2013	18.05.2013
9	19.05.2013	Б.Ур	19.05.2013	19.05.2013	19.05.2013
10	20.05.2013	Б.Ур	20.05.2013	20.05.2013	20.05.2013
11	21.05.2013	Б.Ур	21.05.2013	21.05.2013	21.05.2013
12	22.05.2013	Б.Ур	22.05.2013	22.05.2013	22.05.2013
13	23.05.2013	Б.Ур	23.05.2013	23.05.2013	23.05.2013
14	24.05.2013	Б.Ур	24.05.2013	24.05.2013	24.05.2013
15	25.05.2013	Б.Ур	25.05.2013	25.05.2013	25.05.2013
16	26.05.2013	Б.Ур	26.05.2013	26.05.2013	26.05.2013
17	27.05.2013	Б.Ур	27.05.2013	27.05.2013	27.05.2013
18	28.05.2013	Б.Ур	28.05.2013	28.05.2013	28.05.2013
19	29.05.2013	Б.Ур	29.05.2013	29.05.2013	29.05.2013
20	30.05.2013	Б.Ур	30.05.2013	30.05.2013	30.05.2013

Зураг 6. Шинжилгээнд хамрагдсан ажилчдын бүртгэл



Эргэлтийн шилний тоо ширхэгийн мэдээлэл

	Үйлдвэрлэл /Тоо ширхэг	Эргэлтийн шил /Тоо ширхэг	Үйлдвэрлэлд зарцуулсан %
2025 он	2,325,324	383,446	16%
2024 он	3,904,677	581,026	15%

Мэдээ бэлтгэсэн: Нягтлан бодогч /Ш.Баасан/

Зураг 9. Эргэлтийн шилний тоо ширхэгийн мэдээлэл



Зураг 10. Хаягдал шил авах гэрээ

УЛААНБААТАР ХОТ  
БАТЛАВ  
"ЭЛЕМЕНТ" ХХК-ИЙ ЕРӨНХИЙ  
ЗАХИРАЛ  
*Б. Энхбадрал*  
З. БАЯРСАЙХАН

УЛААНБААТАР ХОТ  
БАТЛАВ  
"ЖЕМ ИНТЕРНЭШНЛ" ХХК-НИЙ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
*Б. Ойгонгэрэл*  
Б. ОЙГОНГЭРЭЛ

Эмнэлгийн аюултай болон эрсдэлтэй хог хаягдлыг тээвэрлэх,  
Халдваргүйжүүлэх, устгах, аюулгүй болгох гэрээ

№ 21/50


2021 оны 08-р сарын 20 -ний өдөр

Улаанбаатар хот

**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1 Нэг талаас "Элемент" ХХК /цаашид гүйцэтгэгч гэх/ төлөөлж, санхүү хариуцсан захирал **Б.Энхбадрал**, нягтлан бодогч албан тушаалтай **Н.Пүрэвсүрэн** нөгөө талаас **Жем Интернэшнл ХХК**-ийг /цаашид захиалагч гэх/-ыг төлөөлж Чанар, Удирдлагын албаны дарга албан тушаалтай Нацагдорж овогтой Нямгарав бид нар харилцан тохиролцож Монгол Улсын Иргэний хууль, Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль, "Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар" болон Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/505 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 605 дугаар тушаал, байгаль орчны холбогдох хууль, дүрэм журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.
- 1.2 Энэхүү гэрээний зорилго нь гүйцэтгэгч тал нь эмнэлгээс гарч байгаа пср шинжилгээтэй хамааралтай аюултай болон халдвартай хог хаягдлыг гэрээнд заасан хугацаанд ачиж тээвэрлэх, халдваргүйжүүлж устгах, захиалагч тал нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх болон байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

*Зураг 11. Аюултай хог хаягдлыг*



*Зураг 12. Шил авах цэг*



Зураг 13. Шил авах цэг



Зураг 14. Шил авах цэг

**СУПЕР СУГАЛААТ АЯН**

**Red Bull 100'000'000 ТӨГРӨГИЙН ТАГЛААНЫ ЛАЦ**

RED BULL ORIGINAL 250 БҮТЭЭГДЭЖҮҮНЭЭ УУГААД ТАГЛААНЫ ЛАЦЫГ САЛГАН АВНА.

ТАГЛААНЫ ЛАЦЫГ ОНООГДСОН ЦЭГТ АВРИН ӨГЧ ОР КОД БҮХНЭЙ СУГАЛААГААР СОЛЫЖ АВНА.

ORIGINAL RED BULL.MN ВЭБСАЙТАД БҮРТГҮҮЛЖ ОР КОДЫГ УНШУУЛАН СУГАЛААГ ИДЭВХЭЖҮҮЛНЭ.

**САР БҮРИЙН АЗТАН:** САР БҮРИЙН 15-НЫ ӨДӨР ӨМНӨХ САРД БҮРТГЭГДСЭН СУГАЛААГААР

2023.10.15 2023.11.15 2023.12.15 2024.01.15

Киккоробот F2Pro iPad MacBook Air iPhone 12Pro

Red Bull Energy Drink (3 сарын сарын) Apple AirPods 4 Logitech Gaming Mouse Logitech G Pro X2

**ЗЭРЭГ ШАГНАЛЫН ЭЗЭД ТОДОРНО.**

Жишээ нь: 12/15-ны тохиолдолд 11/15-аас 12/14 өдрийн 00:00 цаг хүртэл бүртгэгдсэн сугалаа орно.

**СУПЕР АЗТАН:** 2026 ОНЫ 02-Р САРЫН 15-НД ХӨТӨЛБӨРИЙН ТУРШ БҮРТГЭГДСЭН БҮХ СУГАЛААНААС СУПЕР ШАГНАЛ - **100'000'000** ТӨГРӨГИЙН ЭЗЭН ТОДОРНО.

**МОНГОЛ УЛСЫН ХААНААС Ч ОРОЛЦОХ БОЛОМЖТОЙ.**

**"100,000,000 ТӨГРӨГИЙН ТАГЛАА" ХӨТӨЛБӨР НЬ 2026-01-31 ӨДРИЙГ ХҮРТЭЛ ҮРГЭЛЖИЛНЭ.**

**ТОХИРЛЫГ:** ORIGINAL RED BULL.MN ВЭБ САЙТ ДЭЭР ЯВУУЛАХ БӨГӨӨД ШУУД ДАМЖУУЛАЛТЫГ ([www.facebook.com/redbullmongolia](http://www.facebook.com/redbullmongolia)) ФАЙСБҮҮК ХУУДСААР ДАМЖУУЛНА.

**СУГАЛАА ОЛГОХ ЦЭГ:** УЛААНБААТАР ИХ ДЭЛГҮҮР, ЖЕМ ТРЕЙД ХХК ТӨВ ОФИС.

9436 9440 | 7799 7799 RedBullMongolia redbull.mongolia

Зураг 15. Нийгмийн хариуцлагын хүрээнд гүйцэтгэсэн ажил